



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/102

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/ 29.2, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит 4 дүгээр хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд хөндлөнгийн судалгаа хийлгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /н.Жанболат/-т даалгасугай.

2. Дээрхи судалгааны ажилд шаардагдах 5000000 /Таван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын бусад сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ